



ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Төв аймгийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70272582, 99014557
И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273465, 99859811
И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Аудитор: О.Сосор
Утас: 70273204, 97020991
И-мэйл: Sosor@yahoo.com

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон
Төв аймаг Зуунмод хот
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Монгол туургатан театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2016/198/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 03 дугаар сарын 22-ноос 2017 оны 03 дүгээр сарын 24-ныг хүртэл хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн аудитор О.Сосор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Монгол туургатан театрын 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2017 оны 03 дугаар сарын 22-ноос 2017 оны 03 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 25 -нд Монгол туургатан театрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын агентлаг /цаашид "агентлаг" гэх/-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1-д “агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Монгол туургатан театрын Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын БСШУЯамнаас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 16.5. Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нийцлийн аудитын стандар 4200, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн асoлoус программ уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Монгол туургатан театрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас

хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Монгол туургатан театрын төсвийг Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2016 онд санхүүжилт 614198.0 мянган төгрөгөөр батлагдсан. Тайлант онд улсын төсвөөс 574198.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 6964.0 мянган төгрөг, нийт 581162.0 мянган төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлсэн. Урсгал зардалд 581034.0 мянган төгрөгийг зарцуулж 128.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс,орон нутгийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллаганы ил тод ,нээлттэй , ойлгомжтой байх, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар 2016 онд шилэн дансанд байгууллагын мэдээллийг 16 мэдээлэл хугацаандаа, 10 хугацаа хоцорсон, 8 огт мэдээлээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх ,чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна .

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад мөнгөн хөрөнгийн 500,0 мянган төгрөгөөс дээших 122 ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 86.3 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна.

1. Жилийн эцсийн тооллогын дүнг комиссын хурлаар хэлэлцээгүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: ТБОНӨТХуулийн 72.4 комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэх гэсэн заалтыг баримтлан ажиллах зөвлөмж бичсэн.

2. Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 33036.0 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулан ажиллах зөвлөмж бичсэн.

3. Өмнөх оны авлагын үлдэгдэл 2556.8 мянган төгрөгийг бүрэн барагдуулаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь Өмнөх оны үлдэгдлийг бүрэн төлж барагдуулах зөвлөмж бичсэн.

Материаллаг бус залруулсан алдаануудын

талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус 17135.9 мянган төгрөгийн материаллаг бус алдааг залруулсан болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 35619.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөрчлийг гаргахгүй байх талаар зөвлөмж бичлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн явцын аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 100 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь 33036.0 мянган төгрөг буюу 82.5 хувиар тасалсан нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх байх гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Дээрхи зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Монгол туургатан театрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудасыг хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.ЖАРГАЛСАЙХАН
О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

О.СОСОР

Огноо:2017.03.24